



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/265

Есөнбулаг сум

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ний өдрийн 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 03 дүгээр сарын 05-ний өдрийн 64 дугаартай "Хөрөнгийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн хүрээнд "Тайшир гуулин усан цахилгаан станц" (3245845)-ийн эзэмшилд олгогдсон төрийн захиргааны зориулалттай 8208002334 нэгж талбарын дугаартай 375м2 газрын эрхийг "Тайшир ногоон эрчим" төрийн өмчит хувьцаат компани (3268675)-д эрх шилжүүлэн олгож эзэмшил газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн "Тайшир ногоон эрчим" төрийн өмчит хувьцаат компаний мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж, газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны А/21 дүгээр захирамжуудын холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай,

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ



ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	"Тайшир ногоон эрчим" ТӨХК	3268675	Эзэмших	8208002334	375	Жинст баг	Төрийн захиргааны байгууллага (2101)	15